



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 12/07

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль-ийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар зөвлөмжийн дагуу эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн 3 дугаар багц хүзүү толгой шүдний дэлгэмэл компьютерыг 230,000,000 (хоёр зуун гучин сая) төгрөгөөр Сүкэхолдинг ХХК-иар, 4 дүгээр багц суурийн ЭХО аппаратыг 198,550,000 (нэг зуун ерэн найман сая таван зуун тавин мянган) төгрөгөөр Био мед трейд ХХК-иар тус тус гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Д.Баянмөнх), гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Ерөнхий санхүүч (Г.Ганчөдөр) нарт даалгасугай.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын шаардлагад нийцээгүй 6 дугаар багц ариутгал угаалгын тоног төхөөрөмжийг хүчингүй болгосугай.

4.Дээрх хүчингүй болсон багцыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Д.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Т.ДАШЖАНЦАН